



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/2134

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 262 дугаар зүйлийн 262.1.2 дахь заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/274 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад хамруулах журам”-д доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/ Дөрөв дэх хэсгийн 4.3 дахь заалт:

“4.3.Алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжийн дарга суралцах хүсэлт гаргасан алба хаагчтай “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн бакалавр /эчнээ/ суралцах алба хаагчтай байгуулах сургалтын гэрээ”-г байгуулна.”

2. Мөн журмын 8.3 дахь заалтын “бусад нэмэгдлийг” гэснийг “цолны, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг” гэж, 8.5 дахь заалтын “суралцаж байх хугацаанд” гэснийг “Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1 дэх хэсэгт заасны дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хошууч С.Батбямба/-т даалгасугай.

ДАРГА, ХУРАНДАА

Д.ДАМДИНЦЭРЭН

0002165



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2015 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/274

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6.1.1 дэх заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад хамруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг бие бүрэлдэхүүнд судлуулан, мөрдөж ажиллахыг газар, хэлтэс, тасгийн дарга, хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хурандаа М.Алтан-Очир/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2008 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/31 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Б.БИЛЭГТ

0005704

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙГ БАКАЛАВР, МАГИСТР, УДИРДЛАГА, ДОКТОРЫН СУРГАЛТАД ХАМРУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах журам зэрэг холбогдох бусад эрх зүйн актаар зохицуулагдана.

1.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын /цаашид “Захиалагч” гэх/ ажилтан, алба хаагчийг /цаашид “Суралцагч” гэх/ дээд боловсрол эзэмшүүлэх, мэргэжил, мэргэшлийн ур чадварыг нэмэгдүүлэх, эрдмийн зэрэг, цол хамгаалуулах зорилгоор магистр, удирдлага, докторын сургалтад хамруулахад энэхүү журмыг баримтална.

1.3. Бакалавр, магистр, удирдлага, докторын зэрэг олгох сургалтад хамруулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын дундаас хууль зүйн ухааны болон бусад салбар шинжлэх ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх мэдлэг, чадвар эзэмшсэн, цаашид тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллах алба хаагчдыг сонгон суралцуулна.

**Хоёр. Бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад суралцах алба хаагчдад тавигдах шаардлага**

2.1. Бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад суралцах алба хаагчид дараах нийтлэг шаардлага хангасан байна.

2.1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжид ажиллаж байгаа, цаашид тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй;

2.1.2. Сургалтад хамрагдахыг хүссэн алба хаагч нь сүүлийн нэг жилийн хугацаанд сахилга, ёс зүйн зөрчил гарган, сахилгын арга хэмжээ авагдаагүй байх;

2.1.3. Цаашид судалгаа, шинжилгээний ажил хийх хүсэл сонирхолтой;

2.2. Хууль сахиулахын их сургуулийн бакалаврын өдрийн ангид суралцахыг хүссэн алба хаагч дараах тусгай шаардлага хангасан байна.

2.2.1. Бакалаврын өдрийн ангид суралцахыг хүссэн алба хаагч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан байх;

2.2.2. Тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноог хангасан байх.

2.3. Бакалаврын эчнээ сургалтад хамрагдахыг хүссэн алба хаагч дараах тусгай шаардлагыг хангасан байна.

2.3.1. Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн эчнээ сургалтад суралцахыг хүссэн алба хаагч хорих анги, алба, салбар нэгжид 3-аас доошгүй жил ажилласан байх;

2.3.2. Дотоодын их, дээд сургуульд суралцахыг хүссэн алба хаагч хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжид 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.3.3. Тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноог хангасан байх.

2.4. Хууль сахиулахын их сургуулийн болон дотоодын бусад их, дээд сургуулийн магистрын сургалтад хамрагдахыг хүссэн алба хаагч дараах шаардлагыг хангасан байна.

2.4.1. Хууль сахиулахын их сургуулийн магистрын сургалтад суралцахыг хүссэн алба хаагч нь бакалаврын боловсрол эзэмшснээс хойш 3-оос доошгүй жил Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тогтвор суурьшилтай ажилласан байх;

2.4.2. Дотоодын их, дээд сургуулийн магистрын сургалтад суралцахыг хүссэн алба хаагч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.4.2. Бакалаврын дипломын голч дүн суралцахыг хүссэн сургуулийн тухайн жилд тавигдах бакалаврын дипломын голч дүнд хүрсэн байх;

2.4.3. Үндэсний тагнуулын академийн магистрт суралцахыг хүссэн алба хаагч дараах тусгай шаардлагыг хангасан байна.

а. Үндэсний тагнуулын академи болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий их, дээд сургуулийг бакалаврын зэрэгтэй төгссөн байх;

б. Иргэний их, дээд сургууль төгссөн бол гүйцэтгэх ажлын мэдлэг олгох дамжаанд суралцаж, гэрчилгээ авсан байх;

в. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гүйцэтгэх ажлын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх;

г. Үндэсний тагнуулын магистрт суралцахыг хүссэн алба хаагчдыг суралцуулахдаа Тогтоол гүйцэтгэх газраас санал авна.

2.5. Хууль сахиулахын их сургуулийн Удирдлагын академид суралцахыг хүссэн алба хаагч дараах тусгай шаардлагыг хангасан байна.

2.5.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн мэргэжлээр суралцаж, дээд боловсрол эзэмшсэн байх;

2.5.2. Бакалаврын дипломын голч дүн 3.0 (80%) ба түүнээс дээш байх;

2.5.3. Бакалаврын боловсрол эзэмшсэнээс хойш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;

2.5.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн байх;

2.5.5. Төрийн тусгай албаны буюу ТТ-13-14 зэрэглэлийн албан тушаалын нөөцөд авагдсан 35 хүртэлх насны, 15-16 зэрэглэлийн албан тушаалын нөөцөд авагдсан албан тушаалтан 40 хүртэлх настай байх.

2.6. Докторын сургалтад хамрагдахыг хүссэн алба хаагч дараах тусгай шаардлагыг хангасан байна.

2.6.1. Магистрын зэрэг хамгаалснаас хойш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх;

2.6.2. Байгууллагын болон мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээ, судалгааны 5-аас доошгүй бүтээл, өгүүлэл нийтлүүлсэн байх;

2.6.3. Нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага гаргасан эсхүл хамтран оролцсон, байгууллагын хууль тогтоомжийг боловсронгуй болгох шинэчлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх;

2.6.3. Магистрын дипломын голч дүн суралцахыг хүссэн сургуулийн тухайн жилд тавигдах дипломын голч дүнд хүрсэн байх.

**Гурав: Бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад суралцах алба хаагчдыг бүртгэх**

3.1. Энэхүү журмын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5 дахь хэсэгт заасан тавигдах шаардлага хангасан алба хаагчдын бүрдүүлэх материалыг хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн даргын суралцуулах санал, зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хамт бүрдүүлэн Албаны сургалт, дадлагын хэлтэст тогтоосон хугацаанд ирүүлнэ.

3.2. Хууль сахиулахын их сургууль болон дотоодын их, дээд сургуульд суралцахыг хүссэн алба хаагч дараах материалыг бүрдүүлнэ.

3.2.1. Бакалаврт суралцахыг хүссэн алба хаагч Ерөнхий эрдмийн шалгалт өгсөн батламж хуудас, гэрчилгээ /эх хувиар/;

3.2.2. Магистр, удирдлагын сургуульд суралцахыг хүссэн алба хаагч бакалаврын дипломын хуулбар /баталгаажуулсан, шаардлагатай тохиолдолд эх хувиар/;

3.2.3. Докторын сургалтад суралцахыг хүссэн алба хаагч магистрын дипломын хуулбар /баталгаажуулсан, шаардлагатай тохиолдолд эх хувиар/;

3.2.4. Суралцахыг хүссэн өргөдөл;

3.2.5. Төрийн албан хаагчийн анкет 1-р маягт;

3.2.6. Цахим үнэмлэхний хуулбар /баталгаажуулсан/;

3.2.7. Албаны үнэмлэхний хуулбар /баталгаажуулсан/;

3.2.8. 4x3, 4x6 хэмжээтэй гэрэл зураг тус бүр 2 хувь /сүүлийн 6 сарын хугацаанд авахуулсан байх/;

3.2.9. Шаардлагатай тохиолдолд нэмэлт материал бүрдүүлнэ.

3.3. Энэхүү журмын 3.2 дахь хэсэгт заасан бүрдүүлэх материалыг Албаны сургалт, дадлагын хэлтэс хүлээн авч, Захиргааны удирдлагын газрын даргад танилцуулна.

**Дөрөв: Алба хаагчдад суралцах эрх олгох**

4.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь Хууль сахиулахын их сургууль болон бусад их, дээд сургуульд суралцахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зөвшөөрөл авна.

4.2. Суралцах хүсэлт гаргасан алба хаагчдыг элсэлтийн шалгалтад орох, суралцах эрх олгох асуудлыг Захиргааны удирдлагын газар шийдвэрлэнэ.

**Тав: Бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад суралцах алба хаагч, захиалагч байгууллагын эрх, үүрэг**

**5.1. Захиалагчийн эрх, үүрэг**

5.1.1. Алба хаагчийг суралцаж буй сургуулиас ирсэн дуудах бичгийн дагуу тогтоосон хугацаанд сургалтад хамруулах;

5.1.2. Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авах бол энэ тухайгаа хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн даргаар уламжлуулан Албаны сургалт, дадлагын хэлтэст албан бичгээр ирүүлэх бөгөөд чөлөө олгуулах саналыг Албаны сургалт, дадлагын хэлтэс Хууль сахиулахын их сургуульд хүргүүлнэ.

5.1.3. Суралцагчаас гаргасан хүсэлтийн дагуу нууцын зэрэгт хамаарагдахаас бусад баримт бичиг, судалгаа, бусад материалыг гаргаж өгөх;

5.1.4. Байгууллага суралцагчийн тогтоосон хугацаанд сургалтын хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй, хангалтгүй дүн үзүүлсэн тохиолдолд сахилгын арга хэмжээ авах.

5.1.5. Докторын зэрэг хамгаалах тохиолдолд цалинтай, бүтээлийн чөлөөг 2 сар хүртэл хугацаагаар олгох;

**5.2. Суралцагчийн эрх, үүрэг.**

5.2.1. Суралцах хугацаандаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ёс зүйн хэм хэмжээ, сургуулийн дотоод дүрэм, журам, зааврыг чанд сахин биелүүлэх;

5.2.2. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан хичээл сургалтад бүрэн хамрагдаж, эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмших;

5.2.3. Суралцахтай холбоотой үүссэн гомдол, санал, хүсэлтээ албан бичгээр гаргах;

5.2.4. Магистр, удирдлага, докторын сургалтад хамрагдаж буй алба хаагч нь магистрын дипломын ажил, докторын диссертацийн ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг түлхүү хийхийг урьдал болгоно.

5.2.5. Бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад хамрагдаж төгссөн алба хаагч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллана.

**Зургаа. Бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад суралцах алба хаагчдыг дадлага сургалтад хамруулах**

6.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь суралцагч алба хаагчийг танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийх нөхцөл боломжоор хангаж ажиллана.

6.2. Тухайн сургуулиас баталсан дадлага хийх ерөнхий хуваарийн дагуу Албаны сургалт, дадлагын хэлтэс суралцагчийн танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын удирдамжийг боловсруулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргаар батлуулна, шаардлагатай тохиолдолд дадлагын удирдамжийг ШШГЕГ-ын дарга тухайн сургуулийн захирлын хамтарсан тушаалаар батална.

6.3. Дадлага хийж буй алба хаагчдын дадлагын үйл явцтай Албаны сургалт, дадлагын хэлтэс танилцаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

6.4. Алба хаагчид дадлагын хугацаанд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахих, дадлагыг хоцрогдол, таслалтгүй гүйцэтгэх, хариуцан ажиллаж буй дадлага удирдагчийн өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр бүрэн биелүүлнэ.

#### **Долоо. Бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтын төлбөр**

7.1. Бакалавр, түүнээс дээш шатны сургалтад хамрагдаж буй алба хаагч дараах байдлаар сургалтын төлбөрийг төлнө.

7.1.1. Байгууллагын зардал;

7.1.2. Хувийн зардал;

7.1.3. Сургалтын тэтгэлэгт хөтөлбөр.

7.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад суралцаж буй алба хаагчийн сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлж болно.

7.3. Суралцагч нь сургалтын төлбөртөө дэмжлэг хүссэн тухай өргөдлөө Албаны сургалт, дадлагын хэлтсээр уламжлуулан Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газраар шийдвэрлүүлнэ.

#### **Найм. Бусад зүйл**

8.1. Докторын зэрэг хамгаалсан алба хаагчийг шагнаж, урамшуулах асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга шийдвэрлэнэ.

8.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар бакалавр, магистр, удирдлага, докторын зэрэг хамгаалах сургалтад хамрагдахыг хүссэн алба хаагчийн материал болон зэрэг хамгаалсан тухай гэрчлэх диплом холбогдох бусад баримт бичгийг Албаны сургалт, дадлагын хэлтэс хүлээн авч Хүний нөөцийн тасагт шилжүүлнэ.

8.3. Энэхүү журмын 5 дугаар хэсгийн 5.2.5-д хэсгийн заасан хугацаанд сахилга ёс зүйн зөрчил гарган ажлаасаа халагдсан, дээрх хугацаанд ажиллаагүй тохиолдолд 7 дугаар хэсгийн 7.2-д хэсэгт заасны дагуу байгууллагаас сургалтын төлбөрт дэмжлэг авсан бол буцаан төлнө.

8.3. Суралцагчийн суралцах хугацаанд нь үндсэн цалин болон бусад нэмэгдлийг олгох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл, сургалтад хамрагдаагүй бол хичээлийн нэг өдрийг ажлын нэг өдрөөр тооцон, цагийн бүртгэлд бүртгэж цалин, урамшууллыг хасаж тооцно.

8.4. Алба хаагчийн суралцаж буй сургуулиас ирүүлсэн сурлагын хангалтгүй дүн, ирцийн тодорхойлолт нь сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

8.5. Бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад суралцаж буй алба хаагчдын ээлжийн амралтыг Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн ажлын ачааллыг харгалзан, суралцаж байх хугацаанд олгоно.

8.6. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолдалба хаагчдад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны сахилгын дүрмийн дагуу сахилгын шийтгэл оногдуулна.

---o0o---